



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 519

Улаанбаатар хот

“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх МОН2719/0240 төсөл”-ийн хурээнд Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт баригдаж буй Логистикийн төвийг ашиглах бэлтгэл ажлыг хангуулах шаардлагыг харгалзан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор баталсан ““Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолын 1 дүгээр хавсралтын 7-д Нийт ажиллагсдын тоо “...185...” гэснийг “... 227 ...” гэж, 15-д “Ложистикийн төв” төсөлд санхүүжүүлэх дүн “ ...93,954,0 мянган төгрөг...” гэснийг “... 261,795,0 мянган төгрөг...” гэж тус тус өөрчилсүгэй.

2.Компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд өөрчлөлт орсонтой холбогдуулан компанийн 2018 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авалтын төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулан баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал Б.Цэнгэлд даалгасугай.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002437